



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	2
<hr/>	
<i>1.Горимын санал</i>	2

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах/-ны 03 дугаар сарын 15-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 40 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут;

Чөлөөтэй: Ц.Туваан.

Түр хорооны дарга Ж.Чинбүрэн Хянан шалгах түр хорооны дотоод асуудал ярих учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 0

Бүгд: 4

100 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 02 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 14 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим 14 цаг 40 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүдийн
энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан
нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий
Хянан шалгах түр хорооны гишүүдийн
ирц бүрдсэн тул Түр хорооны
хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Хуралдааны ирцийг танилцуулъя.
Ирсэн дарааллаар нь Сандагаа гишүүн
ирсэн байна. Жаргалмаа гишүүн орж
ирсэн, Бэйсен гишүүн ирсэн. Ингээд ирц
57.1 хувьтай байна. Өнөөдрийн
хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ
ээ.

1.Шинжилгээний төлбөрийн
хэмжээг батлах тухай Хянан шалгах
түр хорооны тогтоолын төсөл,

2.Тусгай шалгалтын үйл
ажиллагаатай холбоотой зардлын
хэмжээг батлах тухай Хянан шалгах
түр хорооны тогтоолын төсөл,

3.Хянан шалгагч шинжээч нарын
гүйцэтгэсэн ажлын явцын талаарх
мэдээлэл сонсох гэсэн 3 асуудлыг
хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудлын талаар
саналтай гишүүд байна уу? Алга байна
хэлэлцэх асуудалдаа оръё.

Өнөөдрийн хурлаар Хянан шалгах
түр хорооны хянан шалгагч шинжээч
нарын хяналт шалгалтын явц үр дүнгийн

талаар мэдээлэл сонсох мөн тусгай
шалгалтын сэдвийн дагуу Түр хороо
зөвхөн өөрийн үйл ажиллагааг зохион
байгуулахтай холбоотой асуудлыг
хэлэлцэх учраас хуралдааныг хаалттай
горимоор явуулах саналыг гаргаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь
хэсгийг тус тус үндэслэн хуралдааныг
хаалттай горимд шилжүүлэх горимын
саналаар санал хураалт явуулъя.

Гишүүдийн 100 хувийн саналаар
горимын санал дэмжигдлээ.

Хуралдааныг хаалттай горимд
шилжүүлнэ үү.

14.42 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА